



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН
ХОРООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 01

Номгон

Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Албаны даргын баталсан 07/24 дүгээр удирдамжийн дагуу Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг хэлэлцээд **ТЭМДЭГЛЭХ** нь:

Хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Баянхонгор сум

1. Гэр хорооллын гэрэлтүүлэгийг нэмэгдүүлэх, засварлах ажлыг 40,000,000 төгрөгөөр тендер зарлахаар байхад 2 ажил болгон 20,000,000 төгрөгөөр шууд гэрээ байгуулсан.

2. Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 4/16 тогтоолоор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайн болон орон сууцуудын орчинд ангилан ялгах хог хаягдлын сав, цэгийн тоог нэмэгдүүлэх ажилд 190,000,000 төгрөгийг баталсныг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын худалдааны 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 6/36 дугаар тогтоолоор багийн нийтийн эзэмшлийн 5 байршилд 15,000,000-20,000,000 төгрөгийн төсөвтэй хэд хэдэн ажил болгон тендер зарлалгүйгээр дараах 5 аж ахуйн нэгж байгууллагуудтай 94,950,000 төгрөгийг шууд гэрээг байгуулан гүйцэтгүүлж ажилласан байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр Баянхонгор сумын 7 багт орчин үеийн стандартад нийцсэн хүүхдийн тоглоом, сүүдрэвч, 3x3 сагсан бөмбөгийн талбай хийх ажилд тендер зарлаагүй 14 ажил болгон 6 аж ахуйн нэгж байгууллагуудтай 208,461,900 төгрөгийн гэрээг байгуулан, 2022 онд үлдэгдэл санхүүжилт 51,279,138 төгрөгийг олгосон байна.

4. Бөхт трейд ХХК-тай Номгон сургуулиас Нэгдэлчин зочид буудал хүртэлх авто замын зүүн талаар хогийн сав нэмэгдүүлэх гэрээг 2022 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн БХАБХСЗДТГ/202208021/ дугаартай 20,000,000 төгрөгийн гэрээг байгуулж хяналт зардалд 200,000 төгрөгийг суутгахаар байхад суутгаагүй.

5. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хуучнаар 12 дугаар байрны баруун баруун талын хэсгийн явган замыг ажлыг хийж гүйцэтгэхээр иргэн Т.Шоовдортой 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 20,000,000 төгрөгийн гэрээг байгуулан хяналтын зардал 1 хувь буюу 200,000 төгрөгийн зардлыг суутгаагүй олгосон байна.

642102084

6. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг хугацаанд багтаан сумын Засаг даргын захирамжаар томилсон ажлын хэсэг хүлээн авсан байхад тус хөрөнгүүдийн санхүүгийн тайлант бүртгэл асуудлыг тус бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээгүй.

7. Баянхонгор сумын 2021 оны эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 90,387,700 төгрөгийн орлогын төлөвлөгөөг төлөвлөхөөс 38,530,500 төгрөгийг орлогын төлөвлөгөөг баталж 51,857,200 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

8. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар төсөл хөтөлбөрт арга хэмжээнд гэрээний дагуу 2023 онд олгох 38,221,300 төгрөгийн санхүүжилтын өглөгийг үүсгэсэн.

Өлзийт сум

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар өвс тэжээлийн 3,942,700 төгрөгийн авлагатай ажилласан.

2. Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодиттой тооцоолол хийгээгүй 171,845,300 төгрөгөөр дутуу төлөвлөсөн.

Жинст сум

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хүйс 2 дугаар багийн төвийн засварыг ажлыг хийж гүйцэтгэх 3,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээг сумын Засаг дарга Р.Батжаргал Хүйс 2 дугаар багийн Засаг дарга Д.Наранбаатар нар 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгуулан, Багийн Засаг даргын хувийн харилцах дансанд шилжүүлэн засварын ажлыг хийж гүйцэтгэн, тус ажлыг хүлээн авах ажлын хэсгийн гишүүнээр 2 дугаар багийн Засаг дарга Д.Наранбаатар нь ажилласан байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 оны 10 дугаар сарын 09-ний өдөр фитнес тоног төхөөрөмж худалдан авах 10,000,000 төгрөгийн гэрээг сумын Засаг дарга Р.Батжаргал, Иргэн Б.Очирхуяг нар байгуулсан. Бэлтгэн нийлүүлэгдэх фитнесийн тоног төхөөрөмжийг 2021 онд Соёлын төвийн үйл ажиллагааны зардлаас бэлтгэсэн 7,000,000 төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд тус гүйлгээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төлбөрийн акт тогтоосныг барагдуулан, үлдэгдэл 3,000,000 төгрөгийн нэмж тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд тус хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд орлогоор бүртгэсэн ч Соёлын төвийн санхүүгийн тайлангаар хасаагүй давхар бүртгэсэн.

3. Сумын Засаг дарга, Их богдын тэргүүн ХХК-ний захирал Ц.Баярбат нар нь 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 14,000,000 төгрөгийн өвс тэжээл худалдан авах гэрээг байгуулсан байхад Орон нутгийн хөгжлийн сангаас 14,800,000 төгрөгийн гүйлгээг хийж гэрээнд заасан дүнгээс 800,000 төгрөгийг илүү шилжүүлсэн.

Богд сум

1. 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 64,020,300 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр

байхад 2022 оны малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг 59,908,600 төгрөгөөр төлөвлөж, 4,111,700 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

2. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,312 ширхэг нийт 16,408,000 төгрөгийн өвс тэжээлийн бэлтгэн нийлүүлэх гэрээг 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр сумын Засаг даргатай байгуулж 2022 онд 1244 ширхэг 15,550,000 төгрөгийн өвс тэжээлийг нийлүүлж, 67 ширхэг 839,000 төгрөгийн өвс тэжээлийг бэлтгэн нийлүүлээгүй, ажлын хэсэг байгуулж хүлээн аваагүй байна.

3. Өвс тэжээлийн тооцоонд хяналт шалгалтыг хийхэд 2022 оны бэлтгэн нийлүүлэгдсэн 15,550,000 төгрөгийн өвс тэжээлийг ард иргэдэд зээлээр олгож, сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 онд 14,816,000 төгрөгийг төвлөрүүлж, 780,000 төгрөгийн өвс тэжээлийн авлага барагдаагүй байна.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар 55,000,000 төгрөгийн авлагатай үүсгэж ажилласан байна.

Баянлиг

1. 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 125,229,400 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 2022 оны малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг 65,000,000 төгрөгөөр төлөвлөж, 60,229,400 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 4 дүгээр багуудад мал угаалгын ванн хийж гүйцэтгэхээр иргэн Б.Батбаяртай 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 14,315,000 төгрөгийн гэрээг байгуулж ажлын урьдчилгаанд 10,440,500 төгрөгийн олгосон тус ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй байгаа нь Баянлиг сумын Засаг дарга О.Мөнхбат, иргэн Б.Батбаяр нар нь 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр "Баянхонгор аймгийн Баянлиг сумын 3,4 дүгээр багуудад мал угаалгын ванн, тэмээний тарилга туулгын хашаа барих" ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний 3.1-т "Гүйцэтгэгч нь тус ажлыг техникийн тодорхойлолтод тусгагдсаны дагуу 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр эхэлж, 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр ашиглалтад оруулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар төсөл хөтөлбөрт арга хэмжээг хийж гүйцэтгээгүй 2,940,000 төгрөгийн услалтын системийн үнийг авлага үүсгэж ажилласан байна.

Баянговь сум

1. 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 41,877,600 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 2022 оны малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг 34,000,000 төгрөгөөр төлөвлөж, 7,877,600 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар 28,329,010 төгрөгийн өвс тэжээлийн авлага, 70,750,000 төгрөгийн малжуулахын авлага нийт 99,079,010 төгрөгийн авлагатай ажилласан байна.

Шинэжинст сум

1. 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 125,723 толгой малд 37,716,900 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 2022 оны малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг 36,000,000 төгрөгөөр төлөвлөж, 1,716,900 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

2. Шинэжинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар өвс тэжээлийн 4,811,000 төгрөгийн өглөгтэй ажилласан.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих ажлыг гүйцэтгүүлэхээр Сумын Засаг дарга Н.Сайханбаяр, Гуа-Орд ХХК-ийн захирал Б.Наранбаттай 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №БХШЖСЗДТГ/2021/01/006/ дугаартай гэрээг байгуулж барилгын урьдчилгаанд 111,000,000 төгрөгийг олгосон ч тухайн ажлыг дутуу хийж гүйцэтгэсэн байна.(Барилга барих зөвшөөрөл олгогдоогүй байхад тус ажлыг эхэлсэн байсныг аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллагаас зогсоосон байна.)

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 70,000,000 төгрөгийн үнэтэй Хөдөө аж ахуйн газар тариалан, малын тэжээлийн ургамал тариалахад тохиромжтой өндөр хүчин чадалтай трактор худалдан авахаар гэрээг Бөмбөгөр хайрханы төгөл" ХХК-тай байгуулж 69,000,000 төгрөгийн үнэтэй 1996 онд үйлдвэрлэсэн, 2021 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр монгол орж ирсэн Тракторын худалдан авсан тус тракторыг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан гэж хуулийн хяналт байгууллагаар шалгагдаж байна.

Баян-Өндөр сум

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх ажлын хэсгийг 1 дүгээр улиралд багтаан ажлын хэсгийн байгуулаагүй.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд Нийтийн тээврийн зогсоол хийж гүйцэтгэхээр "Бай Баян-Өндөр хоршоо"-той 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр 7,000,000 төгрөгийн №2022/07 дугаартай гэрээг байгуулж ажлын гүйцэтгэлийн урьдчилгаанд 4,900,000 төгрөгийг олгосон ч тус ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар малжуулах зээлийн үлдэгдэл 36,989,182 төгрөгийн авлагатай ажилласан байна.

4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлэх ажлын хэсэг нь техник эдийн засгийн үндэслэлгүй, зах зээлийн үнийн судалгааг хийгээгүй байхад Баян-Өндөр сумын 1 дүгээр багийн төвд 20тн контейнер худалдан авах гэрээг Цэнхэр уулсын буян ХХК-тай 10,000,000 төгрөгийн өртөгтэй хөрөнгийг бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулж гүйцэтгэсэн байна.

5. Баян-Өндөр сумын онгоц буудлын хашаажуулалтын 29,800,000 ажлын хийж гүйцэтгэх гэрээг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр сумын Засаг дарга У.Балжинням, Бөмбөгөр хайрханы төгөл ХХК-ийн захирал С.Анхбаяр нарын хооронд байгуулсан ажлын гүйцэтгэлийн урьдчилгаанд 20,000,000 төгрөгийг олгосон бөгөөд 2022 онд тус ажлыг хүлээлэн авах ажлын хэсэг шаардлага хангаагүй гэж хүлээн аваагүй байна.

6. Сумын төвийн гудамжны өнгө үзэмжийг нэмэгдүүлэхээр айлд өрхийн хашааг засварлах будах ажилд иргэн Э.Батсайхан, Г.Давдайбаатар, Ж.Базаррагчаа нартай тус бүр 20,000,000 төгрөгийн гэрээг байгуулсан нийт 60,000,000 төгрөгөөр айл өрхийн хашааг засварласан байна.

Баянцагаан сум

1. 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 148,427,000 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 2022 оны малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг 133,294,800 төгрөгөөр төлөвлөж, 15,132,200 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Малын тоо, толгой албан татвар шинэчлэн тогтоох тухай” 9/2 дугаар тогтоол нь Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгүүлээгүй байхад 2022 оны Малын тоо, толгойн албан татварын ногдуулалтыг бодож, төлөвлөсөн.

3. Баянцагаан сумын Дэлгэрэх 2 дугаар багийн улаан шалын хоолойд худагт уст цэг гаргах ажлыг хийж гүйцэтгэх тендерт Топ Атлас Дриллинг ХХК нь шалгарч сумын Засаг дарга Н.Гансүх, Топ Атлас Дриллинг ХХК-ийн захирал Ц.Наранбаатар нар нь 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн №2022/06 дугаар гэрээг байгуулж, ажлын гүйцэтгэлийн урьдчилгаанд 39,570,418 төгрөгийг олгосон ч тус ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлээгүй, сумын Засаг даргын захирамжыг үндэслэн санхүүгийн тайланд бүртгэсэн.

Баацагаан

1. Баацагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар 105,081,566 төгрөгийн малжуулахын авлага үүсгэж ажилласан байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлээгүй, сумын Засаг даргын захирамжыг үндэслэн санхүүгийн тайланд бүртгэсэн.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ковш авто машиныг худалдан авах техникийн тодорхойлолтод 2015 оноос хойш үйлдвэрлэсэн, гаалын бичигтэй гэж тусгагдсан байхад Номгон од констракшн ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр 79,700,000 төгрөгийн өртөгтэй Ковш авто машин бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулан бэлтгэн нийлүүлэхдээ 2013 онд үйлдвэрлэсэн ковш авто машиныг худалдан авсан байна.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналтыг хийгээгүй байна.

5. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Сумын 2021 оны үлдэгдэл хуваарилж 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 6/01 дүгээр тогтоол, Хогын машин засварын гүйцэтгэлийг Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд оруулаагүй байна.

6. Айл өрхийн хашааг 3D блок болгохоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20,000,000 төгрөгийн өртөгтэй гэрээг иргэн Э.Батсайхантай байгуулан айл өрхийн хашааг блокон хашаа болгосон.

Баян-Овоо сум

1. Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд Баян-Овоо сумын 2022 оны төсөв баталсан тогтоолыг PDF файлаар оруулаагүй, тогтоолыг иж бүрэн системд оруулаагүй дутуу оруулсан.

2. Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дээр байгаа золбон нохой устгах ажлыг гүйцэтгүүлэхээр Сумын Засаг даргын Тамгын газрын дарга, иргэн М.Үнэнбат, Г.Алтанцоож нартай нохой устгах гэрээг байгуулан ажлын гүйцэтгэлд иргэн М.Үнэнбатад 1,000,000 төгрөг, иргэн Г.Алтанцоожид 600,000 төгрөг, нийт 1,600,000 төгрөгийг олгохдоо татварын 10 хувийн суутгал 160,000 төгрөгийн татварын суутгалыг суутгаагүй.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн Соёлын төвийн кабелийн шугам татах ажил, Сумын төвийн камержуулалтын засвар үйлчилгээний ажил, гүний худаг гаргах ажил, ЭМТ-ийн барилгын халаалтын засварын ажлын Техник эдийн засгийн үндэслэлгүй хэрэгжүүлсэн.

4. Сумын Соёлын төвийн кабелийн шугам татах ажлыг гүйцэтгэхээр "ОССХ" ХХК-тай гэрээ байгуулж ажлын гүйцэтгэлд 6,000,000 төгрөгийг олгосон тус ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

5. Сумын төвийн камержуулалтын засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэх 15,000,000 төгрөгийн гэрээг сумын Засаг дарга Ж.Хатанбаатар, БМБЖБ ХХК-ийн захирал Ц.Мандах нар нь 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж ажлын гүйцэтгэлд 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр БМБЖБ ХХК-ийн төрийн банк дахь харилцах дансанд 15,000,000 төгрөгийг шилжүүлсэн ч тус ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

6. Баян-Овоо сумын Мэргэн 4 дүгээр багт гүний худаг гаргах ажлын гүйцэтгэх 20,000,000 төгрөгийн гэрээг сумын Засаг дарга, ОССХ ХХК-тай байгуулан тус ажлыг 2022 оны 08 дугаар сарын 08-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 09-ний өдрийг дуустал хугацаанд тохиролцон ажлын гүйцэтгэлд 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдөр ОССХ ХХК-ийн хаан банк дахь харилцах дансанд гэрээнд заасан 20,000,000 төгрөгийг бүрэн олгосон ч тус ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

7. Баян-Овоо сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны харилцах баримтыг дансны хуулгатай тулган шалгахад дансны хуулгаар 4 төрлийн нийт 45,000,000 төгрөгийн гүйлгээг зарлага болгосон ч харилцахын баримтанд төлбөрийн баримт бусад анхан шатны баримтгүй байхгүйгээр ажил гүйлгээг хийсэн.

8. 2021 оны эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 165,659,500 төгрөгөөр төлөвлөгөөг хийхээр байхад 150,000,000 төгрөгөөр төлөвлөж 15,659,500 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

9. Малын тоо толгойн албан татварын орлого 2022 онд татварын орлогын төлөвлөгөөний тайлангаар нийт 93,011,400 төгрөг орлого төвлөрсөн байхад орон нутгийн

хөгжлийн санд малын тоо толгойн албан татварын санхүүжилтыг 107,000,000 төгрөгөөр олгож 13,988,600 төгрөгөөр илүү санхүүжүүлсэн байна.

10. Баян-Овоо сумд шинээр дэд бүтэц сайжруулах жишиг гудамж барих ажлыг Голден эко арт ХХК-тай 174,486,400 төгрөгийн гэрээг байгуулан шинээр 4 гудамж барих ажлыг гүйцэтгүүлсэн.

11. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар хийж гүйцэтгээгүй төсөл хөтөлбөрт олгосон санхүүжилтийн 66,000,000 төгрөгийн авлагыг үүсгэж ажилласан байна.

Бөмбөгөр сум

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд Бөмбөгөр сумын спорт заал бүхий багийн хөгжлийн төвийн барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр Халзан хайрхан ХХК-тай гэрээ байгуулж ажилласан тус барилгын ажил 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар дуусаагүй, удаашралтай байна.

2. Сумын төвийн Задгайн 4-р багт камержуулалтын ажлын гүйцэтгэхээр АЙЕТИ ЮНИПИКЕШН ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр ХК-22/09 дугаартай 38,287,600 төгрөгийн гэрээг байгуулан тус гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан ажил дуусгах хугацааг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунган ажлын гүйцэтгэлийн урьдчилгаанд 30,000,000 төгрөгийн олгож хийж гүйцэтгэсэн ч тухайн ажлыг хүлээн аваагүй байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлээгүй, сумын Засаг даргын захирамжаар санхүүгийн тайланд орлогоор бүртгэсэн.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналтыг хийгээгүй байна.

5. Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 2018 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2018 онд нийт 84,366,893 төгрөгийн трактор, техник тоног төхөөрөмжийг зээлээр авч 2022 оны байдлаар 14,366,893 төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Бууцагаан сум

1. Бууцагаан сумын нутаг дэвсгэр дээр байгаа золбин нохой устгах ажлыг гүйцэтгүүлэхээр иргэн О.Эрдэнэбаттай гэрээг байгуулан 69 нохойг устгалд оруулан нийт 1,518,000 төгрөгийн олгохдоо татварын 10 хувийн суутгал 151,800 төгрөгийг суутгаагүй байна.

2. Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга барих ажлын гүйцэтгэхээр Холбоогийн гурван хавцгай ХХК-тай аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 86,000,000 төгрөг, Бууцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 40,000,000 төгрөг нийт 126,000,000 төгрөгийн гэрээг байгуулан 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан байхад тус барилгын ажлыг дуусаагүй байна.

3. Нийтийн эзэмшлийн талбайд авто зам барих хашлага хийх ажлын гүйцэтгэх тендер Холбоогийн гурван хавцгай ХХК нь шалгаран 100,000,000 төгрөгийн өртөгтэй гэрээг байгуулан

ажлын урьдчилгаанд 94,834,000 төгрөгийг олгосон тус ажлыг чанаргүй гүйцэтгэж тухай ажлыг ажил хүлээлцэх комисс хүлээн аваагүй байна.

4. Бууцагаан сумын Навтан инженерийн хийцтэй худаг шинээр барих ажлыг гүйцэтгэхээр Чорьж бүрд ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэсэн ч гэрээнд тусгагдсан захиалагчын хяналтын зардал 160,000 төгрөгийг суутгаагүй байна.

Баянбулаг сум

1. Баянбулаг сумын 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 28,619,000 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 20,000,000 төгрөгөөр төлөвлөж 8,619,000 төгрөгийг дутуу төлөвлөсөн.

2. Сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/31 дүгээр захирамжаар сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан тус гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэлийг гараагүй, тендерийн баримт бичиг байхгүй байна.

Гурванбулаг сум

1. Гурванбулаг сумын 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 40,400,600 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 36,000,000 төгрөгөөр төлөвлөж 4,400,600 төгрөгийг дутуу төлөвлөсөн.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд сумын сургуулийн урлагын заалад тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр Эрдэнэмандал ХХК-тай гэрээ байгуулан 15,000,000 төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 201 дүгээр захирамжаар ажлын хэсгийг байгуулсан ч тус ажлын хэсэг тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсан гэх боловч хяналт шалгалт хугацаанд 650,000 төгрөгийн өртөгтэй урлагын заалныг хаалгыг хийж гүйцэтгээгүй байна.

3. Ус зөөврийн машин нийлүүлэх ажлын гүйцэтгэх тендерт Ган утас мөнх ХХК нь шалгаран 34,773,000 төгрөгийн гэрээ байгуулан ажилласан ч тус аж ахуйн нэгж байгууллага нь техникийн тодорхойлолтод нийцсэн тээврийн хэрэгслийг нийлүүлээгүй байхад хүлээн авч, сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд орлогоор авч бүртгэсэн байна.

4. Өвс тэжээлийн тооцоонд хяналт шалгалтыг хийхэд 2022, 2023 онуудад нийт 18,785,000 төгрөгийн өвс тэжээлийн ард иргэдэд зээлээр олгож, сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2022 онд 409,500 төгрөг, 2023 онд 9,579,000 төгрөг, нийт 9,988,500 төгрөгийг төвлөрүүлж, 8,796,500 төгрөгийн өвс тэжээлийн авлага барагдаагүй байна.

5. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар нийт 128,000,000 төгрөгийг малжуулахын авлагатай ажилласан байна.

Заг сум

1. Орон нутгийн сангийн хөрөнгөөр 2022 онд сумын төвийн 150 айл өрхийн хашаанд гудамж хороолол тэгш гудамж төсөлд 60,000,000 төгрөгийг зарцуулсан.

2. Өвс тэжээлийн 2021 оны эхний үлдэгдэл 1,442 боодол 17,304,000 төгрөгийн өвс тэжээлийн үлдэгдэлтэй, 2021 онд нийт 21,471,000 төгрөгийн өвс тэжээл худалдан авч, тайлант онд нийт 16,759,600 төгрөгийн өвсийг худалдан борлуулж, 2022 онд 290 боодол 2,322,600 төгрөгийн өвс тэжээл худалдан авч 322 боодол 3,678,000 төгрөгийг худалдан борлуулж, оны эцсээр 2,180 боодол 18,440,500 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2023 оны 2,172 боодол 18,160,500 төгрөгийн өвс тэжээлийн зээлээр борлуулж 2023 онд Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 12,997,000 төгрөг төвлөрч, 280,000 төгрөгийн өвс тэжээл үлдэгдэлтэй, 5,023,500 төгрөгийн өвс тэжээлийн авлагатай байна.

3. Заг сумын 2021 оны эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 37,339,800 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 20,000,000 төгрөгөөр төлөвлөж 17,339,800 төгрөгийг дутуу төлөвлөсөн.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар нийт 18,509,000 төгрөгийг зураг төсвийн авлагатай ажилласан байна.

Жаргалант сум

1. Өвс тэжээлийн тооцоонд хяналт шалгалтыг хийхэд 2022, 2023 онуудад нийт 49,208,260 төгрөгийн өвс тэжээлийн ард иргэдэд зээлээр олгож, Орон нутгийн хөгжлийн санд 2021 онд 2,575,120 төгрөг, 2023 онд 36,710,000 төгрөг, нийт 39,285,120 төгрөгийг төвлөрүүлж, 2,924,140 төгрөгийн өвс тэжээлийн авлагатай байна.

2. Жаргалант сумын 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 54,105,600 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 36,179,400 төгрөгөөр төлөвлөж 17,926,200 төгрөгийг дутуу төлөвлөсөн байна.

3. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн " сумын 2022 оны төсөв батлах тухай" 5/11 дүгээр тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 7/06 дугаар тогтоолуудыг Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд PDF файлаар оруулаагүй байна.

4. Орон нутгийн сангийн хөрөнгөөр 2022 онд сумын төвийн айл өрхийн хашааг янзлах, гудамж хороолол тэгш гудамж төсөлд 45,000,000 төгрөгийн гэрээг Олз баялаг ХХК-тай гэрээ байгуулан айл өрхийн хашааг засварласан.

Галуут сум

1. Галуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 3/05 дугаар тогтоолоор Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоож 2022 оны малын тоо толгойн албан татварын 116,707,800 төгрөгөөр төлөвлөх байтал 100,000,000 төгрөгөөр төлөвлөж, 16,707,800 төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

2. Галуут сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гудамж хороололын камержуулалт, аянга зайлуулагч хийж ажлыг дутуу хэрэгжүүлж үлдэгдэл санхүүжилт 15,578,600 төгрөгийг олгоогүй 2022 оны санхүүгийн тайлангаар өглөг үүсгэсэн.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд ковш машин худалдан авах тендэрт Шинэ ирээдүйн хөтөч хоршоо шалгарч гэрээ байгуулан 65,000,000 төгрөгийн өртөгтэй ковш бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулсан ч тус бэлтгэн нийлүүлэгдсэн ковшийн эзэмшлийг сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлээгүй, тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Шинэ ирээдүйн хөтөч хоршоонд бүртгэлтэй байна.

4. Галуут сумын Баянхошуу 6-р багт аянга зайлуулагч хийх шууд гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Төгс орхон ХХК-тай 17,000,000 төгрөгийн гэрээг байгуулж, 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр тус ажлын дуусгахаар гэрээнд заасны дагуу ажлын урьдчилгаанд 11,900,000 төгрөгийн олгосон ч тус ажлын хийж гүйцэтгээгүй байгаа нь Галуут сумын Засаг даргын А.Батбаяр, Төгс орхон ХХК-ийн захирал М.Дэлгэрдалай нарын 2022 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр байгуулсан гэрээний 3.1-т "Гүйцэтгэгч нь тус ажлыг техникийн тодорхойлолт, зураг төсөвт тусгагдсаны дагуу 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр эхэлж, 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад оруулна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 2022 онд нийт 151,000,000 төгрөгийн өмч хөрөнгийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлээгүй, санхүүгийн тайланд орлого аваагүй байна.

6. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар төсөл хөтөлбөрт арга хэмжээнд олгох 15,587,600 төгрөгийн санхүүжилтанд өглөг үүсгэж ажилласан.

Эрдэнэцогт сум

1. Эрдэнэцогт сумын 2021 оны жилийн эцсийн статистик тоон мэдээнд тулгуурлан малын тоо толгойн албан татварын төлөвлөлтөд тооцоолол хийхэд 2022 оны малын тоо толгойн албан татварыг 84,051,500 төгрөгийн төлөвлөгөөг хийхээр байхад 78,500,000 төгрөгөөр төлөвлөж 5,551,500 төгрөгийг дутуу төлөвлөсөн.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар нийт 6,600,000 төгрөгийг өвс тэжээлийг авлага үүсгэсэн.

3. Эрдэнэцогт сумын Ямаат 2 дугаар багийн төвийн нутаг дэвсгэрт Сүлжээ байгуулах дэд бүтцийн ажлыг хийж гүйцэтгэхээр Оройн гурвалжин ХХК-тай гэрээ байгуулж ажлын урьдчилгаанд 10,000,000 төгрөгийг олгосон тус ажлыг хийж гүйцэтгээгүй, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр 5,000,000 төгрөгийг Эрдэнэцогт сумын Орон нутгийн хөгжлийн санд буцаалт төвлөрүүлж үлдэгдэл 5,000,000 төгрөгийг одоог хүртэл төвлөрүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.7 дах хэсгийг үндэслэн Дотоод аудитын хорооны хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнг баталгаажуулсугай.

2. Санхүүгийн хяналт, аудитын албанаас гаргасан хяналт шалгалтын танилцуулга, үр дүнг хэлэлцээд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр илрүүлэн дүгнэж шийдвэрлэснээр тооцсугай.

3. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д зөвлөсүгэй.

3.1. Өмнөх онуудад үүссэн малжуулахын авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй Баацагаан, Баян-Өндөр, Баянговь, Гурванбулаг, Хүрээмарал сумдын Засаг дарга, батлагдсан төсвийг олон төсөл хөтөлбөр арга хэмжээ болгон хуваан (төндөр) худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан Баянхонгор сумын Засаг дарга нарт хариуцлага тооцох.

4. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт даалгасугай.

4.1 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хяналтын хороо байгуулж, Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжих төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж, үр дүн тооцох.

4.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа төсөл хөтөлбөр арга хэмжээний явцын хяналтыг хийж гүйцэтгэн илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт зөвлөмжийг хүргүүлэн тайланг баталгаажуулан ажиллах.

4.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмчлөл бүртгэх боломжгүй айл өрхийн хашаа гудамж талбайн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох.

5. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нар даалгасугай

5.1. Ажилдаа хариуцлагагүй хандсан Баян-Овоо сумын Санхүүгийн албаны дарга, сан хариуцсан нягтлан бодогч, Хүрээмарал сумын сан хариуцсан нягтлан бодогч нарт хариуцлага тооцох.

5.2. Тогтвортой амьжиргаа 3 төслийн үнэлгээнд ач холбогдол өгч, өмнөх онуудад үнэлэгдсэн үнэлгээг сайжруулах, өмнөх онуудаас үнэлгээг буурсан, хангалтгүй үнэлэгдсэн тохиолдолд дараагийн хяналт шалгалтаар холбогдох албан хаагч нарт арга хэмжээ авахыг анхааруулах.

6. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга, сан хариуцсан нягтлан бодогч нар даалгасугай.

6.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, чанартай хийж гүйцэтгүүлэх.

6.2. Өмнөх онуудад үүссэн малжуулах төслийн авлагыг 365,160,038 төгрөгийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан барагдуулах.

6.3. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг өмчлөлийг тогтоохдоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллах.

6.4. Малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөхдөө өмнөх оны статистикийн тоо мэдээтэй уялдуулан төлөвлөгөөг боловсруулж, Татварын байцаагчтай хамран орлогын биелэлтэд анхаарч ажиллах.

6.5. Хавсралтаар хүргүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх тал дээр арга хэмжээ авч ажиллах.

6.6. Хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд биелүүлж хариуг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэхийг сумдын Засаг дарга, Сан хариуцсан Нягтлан бодогч нарт хариуцуулав.

6.7. Шалгалтаар тогтоосон албан шаардлага, актын төлбөрийг хугацаанд нь барагдуулж, илэрсэн зөрчлийг арилгаагүй зөвлөмжийг биелүүлж хариу ирүүлээгүй тохиолдолд Дотоод аудитын дүрэмд заасан арга хэмжээ авч ажиллахыг анхааруулсугай.

7.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д даалгасугай.

7.1.Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтыг үндэслэн сангийн хөрөнгөөс зориулалт бус зарцуулалт гарсан тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхийг хэрэгжүүлэх.

8.Аймгийн Засаг даргын Тамгын газрын , Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

8.1. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9 дэх заалтыг хэрэгжүүлж, мөрдөх.

8.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн тайланг сум бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох тодорхой шийдвэрийг гаргуулж байх

9.Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Л.Жаргалцэцэг)-д даалгасугай.

9.1.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалтын зөвлөмжийн дагуу ажилласан ажлын гүйцэтгэлийг дүгнэж Дотоод аудитын хороонд танилцуулах.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 12/31

Номгон

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн
үйл ажиллагааг сайжруулах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Албаны даргын баталсан 07/24 дүгээр удирдамжийн дагуу Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмчлөл бүртгэх боломжгүй айл өрхийн хашаа гудамж талбайн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.2-т “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ” гэсэн заалтын мөрдөж ажиллах.

2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн өмчлөлийг тогтоохдоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй”, 77.3-т “Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээг техникийн эдийн засгийн үндэслэлд тулгуурлан санхүүжүүлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, 13.5-т “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник,

842312158

эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

4. Аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээний заалтуудад онцгой анхаарч гүйцэтгэлд тулгуурлан, санхүүжилтийг олгох, ТЭЗҮ, зураг төсөвт тусгагдсан ажлын хугацаанд хийж гүйцэтгэх, гэрээг сунгах нөхцөлийг тодорхой болгох, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд санхүүжилтийн буцаан төсөвт төвлөрүүлэх заалтыг гэрээнд тусгаж оруулах.

5. Ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, гэрээг бүртгэлжүүлж, бүртгэлийн дугаартай болгон Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.7-т “хөрөнгө оруулалт, зээл, тусламж, гэрээ хэлцэл, худалдан авах ажиллагааны болон урт, богино хугацааны төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилттэй холбогдох эх баримт бичгийг тус тусад нь хөтлөх хэрэг бүрдүүлэх” гэсэн мөрдөж ажиллах.

6. Хугацаандаа хийж хэрэгжүүлээгүй төсөл хөтөлбөр арга хэмжээг гэрээнд тусгагдсан заалтын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх.

7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх төсөл хөтөлбөр арга хэмжээг хэд хэдэн ажил болгохгүйгээр багцын нийлбэр өртгийг үндэслэл хуульд заасан босго үнэд багтаан тендер шалгаруулалтын журмыг зохион байгуулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.5-т “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.7.1-т “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

8. Малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөхдөө өмнөх оны статистикийн тоо мэдээтэй уялдуулан төлөвлөгөөг боловсруулж, биелэлтэд анхаарч Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна”, 5.2-т “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно” гэсэн заалтын хэрэгжүүлэх.

9. Удирдлага мэдээллийн нэгдсэн системд орон нутгийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх төсөл хөтөлбөр арга хэмжээний мэдээллийг тухай иж бүрэн оруулж ажиллах.

10. “Малжуулах төсөл” хөтөлбөрийн урьд оны үлдэгдэл, хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийн авлагыг 2024 онд багтаан барагдуулах.

11. Өмнөх онуудад үүссэн өглөг, авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулан барагдуулах талаарх арга хэмжээг авч, өр төлбөр үүсгэхгүй ажиллаж Төсвийн тухай хуулийн 4 зүйлийн 4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

12. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг тухай бүр үнэн зөв бөглөж, гүйцэтгэсэн ажлын тайланг харгалзан үзэж тооцоог шахан гүйлгээг хийж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

13. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хяналтын хороо байгуулж, Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжих төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж, үр дүн тооцох.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хүргүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх тал дээр арга хэмжээ авч ажиллах.

Хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийг хугацаанд биелүүлж хариуг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэхийг бүх сумдын Засаг дарга, Сан хариуцсан Нягтлан бодогч нарт хариуцуулав.

Шалгалтаар тогтоосон албан шаардлага, актын төлбөрийг хугацаанд нь барагдуулж, илэрсэн зөрчлийг арилгаагүй зөвлөмжийг биелүүлж хариу ирүүлээгүй тохиолдолд Дотоод аудитын дүрэмд заасан арга хэмжээ авч ажиллахыг анхааруулсугай.

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

